

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙГМИЙН
САЛБАР, НОГООН ХӨГЖИЛ БОЛОН АГААР,
ОРЧНЫ БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ, "УЛААНБААТАР МАРАФОН-2023" ОЛОН
УЛСЫН ГҮЙЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН ДАРГА

3.ТӨМӨРТӨМӨӨ

2023 оны 04 дүгээр сарын 28

2023 оны 04 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

**"УЛААНБААТАР МАРАФОН - 2023" ОЛОН УЛСЫН
ГҮЙЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго:

1.1.Эх орондоо гүйлтийн спортыг хөгжүүлэх, нийслэл хотоо дэлхийн улс орнуудад сурталчлах, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн оролцоо, сэтгэл ханамж, цар хүрээг нэмэгдүүлэх, өсвөр залуу үеийнхэнийг өөрийн дотоод нөөц боломжийг нээж зорилгодоо хүрэх тэсвэр хатуужилтай болгон бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжил төлөвшүүлэхэд "Улаанбаатар марафон - 2023" олон улсын гүйлт (цаашид "Марафон гүйлт" гэх)-ийг зохион байгуулахад гол зорилго оршино.

1.2.Хамрах хүрээ: Энэхүү марафонд их дээд сургуулийн оюутнууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, нийслэл, дүүргийн төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд, гадаад, дотоодын иргэдийг хамруулна.

Хоёр. Марафон гүйлтийг зохион байгуулагчид:

Ерөнхий зохион байгуулагчид: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар

Хамтран зохион байгуулагчид: "Хай Пэймэнт Солюшнс" ХХК, Монголын Хөнгөн атлетикийн холбоо

Гурав. Зохион байгуулах журам, хугацаа:

3.1.Марафон гүйлтийн нээлтийн ажиллагаа 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 09.30 цагт Д.Сүхбаатарын талбайд болно.

3.2.Марафон гүйлт 10:00 цагт Д.Сүхбаатарын талбай дахь гараанаас дараах дарааллын дагуу байрлан зогсож нэгдсэн дохиогоор зэрэг гарна.

- 42,195 км, 21,095 км, 10 км зайн гүйгчид 1 дэх шугаманд:
- 5 км-ийн 12-17 насны гүйгчид 2 дахь шугаманд:
- 5 км-ийн эрүүл мэндийн гүйлт 3 дахь шугаманд тус тус байрлан зогссон байна.

3.3.Зай тус бүр тогтоосон маршрутаар гүйж Д.Сүхбаатарын талбайд барианд орно. Нийт 42,195 км-ийн марафон гүйлтийн үргэлжлэх хугацаа 6 цаг байна. Хагас, бүтэн марафон гүйлтийн бүх төрөлд оролцогчид 16.00 цаг хүртэл барианд орсон байх шаардлагатай. Хоцорсон тамирчдыг барианд орсноор бүртгэхгүй болно.

3.4.Тэргэнцэртэй, хараагүй оролцогчдын 1,5 км-ийн гараа 13.00 цагт, гэр бүлийн гүйлт 14.00 цагт эхэлнэ.

3.5.Марафон гүйлтийн 10 км, 21,095 км, 42,195 км-ийн зайн гүйлтэд оролцогчдын амжилтыг <https://ubmarathon.hipay.mn/> цахим хуудсанд байршуулна. Бүх оролцогчид

марафон гүйлтэд оролцсон батламжаа дээрх цахим хуудсаас өөрсдөө хэвлэж авах боломжтой.

Тэмцээний зай, төрөл, насны ангилал:

№	Төрөл	Насны ангилал	Ангилал	Дагалдах зүйлс
1.	42,195 км	18+ нас	Эм, эр	Энгэрийн дугаар, дурсгалын медаль, футболк, чип
2.		ХБИ 18+ нас	Эм, эр	
3.	21,095 км	18-34	Эм, эр	Энгэрийн дугаар, дурсгалын медаль, футболк, чип
4.		35-54	Эм, эр	
		55+	Эм, эр	
4.		ХБИ 18+ нас	Эм, эр	
5.	10 км	18+ нас	Эм, эр	Энгэрийн дугаар, футболк, чип
6.	5 км	12-17	Охид, хөвгүүд	Энгэрийн дугаар
		/Эрүүл мэндийн гүйлт/ 18-аас дээш нас		
7.	1,5 км	Тэргэнцэртэй	Эм, эр	Энгэрийн дугаар
		Хараагүй	Эм, эр	
8.	1,5 км	Гэр бүл	Гэр бүл нь 3-4 гишүүнтэй байна. Хүүхэд нь 5-11 настай байх	Энгэрийн дугаар

3.6. Марафон гүйлтийн 10 км маршрутын дагуу хуваарлагдсан талбайд Дүүргийн Засаг даргын тамгын газар иргэдэд зориулсан урлаг, спорт, хүмүүнлэгийн арга хэмжээ, зохион байгуулна.

Дөрөв. Шагнал урамшуулал:

4.1. Хагас буюу бүтэн марафоны 21,095 км, 42,195 км, 10 км зайд гүйж эхний 1-3 дугаар байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй тамирчдад цом, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр, 4-10 дугаар байр эзэлсэн гүйгчдийг дурсгалын медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Бүтэн марафон (42,195 км) гүйлтийн шагнал:

I байр	10.000.000₮
II байр	8.000.000₮
III байр	6.000.000₮
IV-X байр	800.000 – 4.000.000₮

4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (харааны бэрхшээлтэй, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй, саажилт, тулгуур эрхтний бэрхшээлтэй гэх мэт)-ийн (42,195 м)-ийн гүйлтэд гүйж эхний 1-3 дугаар байрт шалгарсан тамирчдад цом, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр, 4-5 дугаар байр эзэлсэн гүйгчдийг дурсгалын медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтэн марафон гүйлтийн шагнал:

I байр	1.500.000₮
II байр	1.200.000₮
III байр	1.000.000₮
IV байр	500.000₮
V байр	500.000₮

4.3. Хагас марафон (21,095 км, 18-34 нас) гүйлтийн шагнал:

I байр	5.000.000₮
II байр	4.000.000₮

III байр	3.000.000₮
IV-X байр	200.000 - 400.000₮

4.4. Марафон гүйлтийн 10 км, 21,095 км (35-54, 55-аас дээш нас)-ийн зайн гүйлтийн шагнал:

I байр	500.000₮
II байр	400.000₮
III байр	300.000₮
IV-X байр	100.000 - 200.000₮

4.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (харааны бэрхшээлтэй, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй, саажилт, тулгуур эрхтний бэрхшээлтэй гэх мэт)-ийн 21,095 км-ийн зайн гүйлтэд гүйж эхний 1-3 байрт шалгарсан тамирчдад цом, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр, 4-5 дугаар байр эзэлсэн гүйгчдийг дурсгалын медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хагас марафон гүйлтийн шагнал:

I байр	800.000₮
II байр	600.000₮
III байр	400.000₮
IV байр	300.000₮
V байр	200.000₮

4.6. Марафон гүйлтийн 5 км-ийн зайд 12–17 насны эхний 1–3 дугаар байрт орсон охид, хөвгүүдийг өргөмжлөл, цом, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар, 4-8 дугаар байрт шалгарсан тамирчдыг дурсгалын медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнана.

5 км-ийн зай /12-17 нас/-н гүйлтийн шагнал:

I байр	200.000₮
II байр	150.000₮
III байр	100.000₮
IV-VIII байр	50.000₮

4.7. Марафон гүйлтийн 1,5 км-ийн зайд гэр бүлийн төрөлд болон тэргэнцэртэй, хараагүй иргэдийн төрөлд гүйж эхний 1-3 дугаар байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй тамирчдыг цом, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр, шагнана.

1,5 км-ийн зайн гүйлтийн шагнал:

I байр	200.000₮
II байр	150.000₮
III байр	100.000₮

Тав. Бүртгэлийн ажиллагаа, хураамж

5.1. Марафон гүйлтэд оролцогчид <https://ubmarathon.hipau.mn/> цахим хуудас болон hipau аппликэйшнаар бүртгүүлэн онлайнаар хураамжаа төлсөн оролцогчдод энгэрийн дугаар олгож баталгаажуулалт явагдана.

5.2. Марафон гүйлтийн бүртгэл 2023 оны 04 дүгээр сараас 17-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл зохион байгуулагдах бөгөөд үүнээс хойш оролцогчдыг бүртгэхгүй ба энгэрийн дугаар олгохгүй.

5.3. Марафон гүйлтийн 5 км-ийн зайд оролцогчийн бүртгэл баталгаажуулалт, энгэрийн дугаар олгох ажил Нийслэлийн 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодод (БГД-ийн БТСХ-95705607; БЗД-ийн БТСХ-85829111; БНД-ийн БТСХ-99704438; БХД-ийн БТСХ 88060874; НД-ийн БТСХ-88057467; ХУД-ийн БТСХ-99663717; СБД-ийн БТСХ-88085975; СХД-ийн БТСХ-99072560; ЧД-ийн БТСХ-88928787) 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл зохион байгуулна.

5.4. Марафон гүйлтийн 42,195 км, 21,095 км, 10 км-ийн зайд оролцогчийн (гадаадын иргэд) бүртгэлийг баталгаажуулж, энгэрийн дугаар, чип, футболк олгох ажил

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Бага тойруу, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байрны нэг давхарт буюу “Зоос гоёл”-ын замын урд) 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэлх өдрүүдэд зохион байгуулагдана. Утас: 70002785, 7766-7700 (hipay), 976-99285651, 976-86050003, 976-90098082, 976-96635753

5.5.Марафон гүйлтийн 1,5 км-ийн зайд оролцогчийн баталгаажуулалт, энгэрийн дугаар олгох ажил Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл зохион байгуулна. (5.4-т заасан байршилд)

5.6.Оролцогчийн иргэний үнэмлэх, гадаад паспорт болон төлбөрийг <https://ubmarathon.hipay.mn/> цахим хуудас, hipay аппликэйшнаар хийсэн баримтыг үндэслэн энгэрийн дугаар олгож бүртгэл баталгаажсанаар гүйлтэд оролцох эрх нээгдэнэ.

5.7.Эрүүл мэндийн гүйлтийн 5 км-ийн зайд оролцогчид нийслэлийн 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороон дээр очиж энгэрийн дугаар авсанаар гүйлтэд оролцох эрх нь баталгаажина.

5.8.Гэр бүлийн гүйлт нь 3-4 хүний бүрэлдэхүүнтэй байна. Хүүхэд 5-11 настай байх, гэрлэсний баталгаа, аав, ээжийн иргэний үнэмлэх, хүүхдийн төрсний гэрчилгээг <https://ubmarathon.hipay.mn/> цахим хуудсаар төлбөр хийсэн баримтын хамт шалган энгэрийн дугаар олгож баталгаажуулна.

5.9. Гүйлтэд оролцогчдын хураамжийн мэдээлэл (дотоод, гадаадын оролцогч)

Гүйлтийн зай	1,5 км	5 км	10 км	21,095 км	42,195 км
Төлбөр	5,000₮	5,000₮	30,000₮	50,000₮	60,000₮

5.10.Марафон гүйлтийн энгэрийн дугаар аваагүй оролцогчдыг барианд барихгүй бөгөөд үзүүлсэн амжилт, хугацааг тодорхойлохгүй.

5.11.Хураамж болон бүртгэлтэй холбоотой мэдээллийг <https://ubmarathon.hipay.mn/>, sport.ub.gov.mn цахим хуудас, hipay аппликэйшнаас авна.

5.12.Марафон гүйлтийн тэмцээний бүх насны ангилалд оролцогчид эмчийн үзлэгт хамрагдан зүрхний цохилт, даралтаа хэмжүүлсэн байна. Хэвийн бус тохиолдолд гүйлтэд оролцохгүй ба оролцсон тохиолдолд хариуцлагаа хувь хүн өөрөө хүлээнэ.

5.13.Марафон гүйлтэнд оролцогчдын байр, хоол, ирэх, буцах унаа болон бусад холбогдох зардлыг тэмцээнд оролцуулж байгаа тухайн байгууллага, хувь хүн хариуцна.

5.14.Марафон гүйлтийн тэмцээн зохион байгуулах өдөр буюу 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 06:00 минутад Д.Сүхбаатарын талбай уруу орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлан хаах тул тус тэмцээнд оролцогчид зам тээврийн асуудлаа зохицуулж Д.Сүхбаатарын талбайн гүйлтийн гараа гарах газар 09:00 цагаас өмнө ирж гарааны шугамын ард байраа эзэлсэн байна.